



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2021.10.21 № 05/11213
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

С. Мөнхбатбаяр
дарга

Хүндэтгэлтэй
дотуу шийгшлэл

Мөнхбатбаяр

Д/Х


Төв аймгийн Соёлын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Батсуурийн Тунгалагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "... тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас ... авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж заасан.

Иймд Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага хангасан этгээдийг нийтийн албанд томилуулахаар нэр дэвшүүлж, дээрх хууль болон өөрийн салбарт мөрдөгдөж буй дүрэм журамд нийцүүлэн түр болон жинхлэн томилох эсэхийг анхаарна уу.

Түүнчлэн нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

Б. Амарингэр
Хүндэтгэлтэй
дотуу шийгшлэл

С. Мөнхбатбаяр
Д/Х

142103018920



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2021.12.14 № 05/13562
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

Б.Ганзориг даргид
Хэрэв тогтоомжийн
дээр үнийг оруулж
Амжилт!
20/12

Төв аймгийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Цэрэнжамцын Нарантуяагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



Г.Ганзориг

Б.Ганзориг хамтараа
хүргийнх!

Handwritten signature

142103022903